

Төслийн мэдээллийн тайлангийн энэхүү орчуулсан хувь нь 2016.оны 6-р сарын 20-ний байдлаарх англи эхэд суурилсан болно.



Монгол Улс: Өмнийн Говьд хот байгуулалт, хил орчмын хот суурин газрын хөгжлийг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт

Төслийн нэр	Өмнийн Говьд хот байгуулалт, хил орчмын хот суурин газрын хөгжлийг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт	
Төслийн дугаар	42184-024	
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс	
Төслийн статус	Батлагдсан	
Төслийн төрөл / Дэмжлэгийн хэлбэр	Зээл Техникийн туслалцаа	
Санхүүжилтийн эх үүсвэр /Мөнгөн дүн	Зээл-3388-MON: Өмнийн Говьд хот байгуулалт, хил орчмын хот суурин газрын хөгжлийг дэмжих төсөл –Нэмэлт санхүүжилт	
	Азийн Хөгжлийн Сан	19.43 сая ам.дол.
	ТА 9100-MON: Бие даасан болон төвлөрсөн бус цэвэрлэх байгууламжийн лагийн дахин ашиглалт, удирдлага	
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчинд тогтвортой хөгжил Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт	
Шинэчлэлийг нөхцөлдлүүлэгч хүчин зүйлс	Засаглал ба чадавхи бэхжүүлэх (ЗЧБ) Түншлэл (ТҮН)	
Салбар /Дэд салбар	Усан хангамж ба хотын бусад дэд бүтэц, үйлчилгээ – Хотын ариутгах татуурга	
Жендерийн тэгш байдал ба төлөвшлийн шинж байдал	Жендерийн зарим холбогдол	

Төслийн тухайд

Энэхүү нэмэлт санхүүжилт болон буцалтгүй тусламжаар хэрэгжих техник тусалцаа нь нэмэлтээр хоёр аймгийн бохир усны шийдлийг чанартай бөгөөд найдвартай болгож, НААҮ-ээг сайжруулах үйл ажиллагаанд томоохон бөгөөд хурдацтай хөгжиж буй хоёр ч аймгийн төвийг нэгтгэж төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг улам бүр нэмэгдүүлж хамрах хүрээг өргөжүүлж байгаагаараа ач холбогдолтой юм. Нэмэлт санхүүжилт олгогдсоноор төсөлд одоо хамрагдаж байгаа болон шинээр хамрагдах аймгуудын НААҮ-ий байгууллагуудын бохир усны менежментийг хэрэгжүүлэх чадавхийг техник тусалцааны төслөөр дамжуулан бэхжүүлнэ.

Төслийн үндэслэл ба Орон\Бүсийн стратегитай үйлдсэн байдал

2010 оны 4-р сарын 19-нд, АХБ Өмнийн Говийн хүн ам төвлөрсөн хот суурин газруудын инженерийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах зорилгоор Өмнийн Говьд хот байгуулалт, хил орчмын хот суурин газрын хөгжлийг дэмжих төслийн санхүүжилт болох 15 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Азийн хөгжлийн сангаас олгохоор баталсан. Тухайн үед уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж хөрш БНХАУ-тай худалдаа хамтын ажиллагааны коридорууд идэвхжиж байсан тул Дорноговь, Өмнөговь аймгуудад эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжиж хүн ам ихээр төвлөрч эхэлсэн хэдий ч аймгийн болон гол сумуудын төвд шаардлага хангах биет дэд бүтэц, үйлчилгээ туйлын хомс байв. Хэрэгжиж буй төслийн гол үр нөлөө тиймээс Өмнийн Говийн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, аймгийн төв, уулуурхайн суурьшлын төвүүд болон хил орчмын хот суурин газруудын тав тухтай нөхцөл байдлыг сайжруулахад оршсон. Төслөөс хүлээгдэх үр дүнгийн хувьд хот байгуулалтат ахиц гарч засаглал бэхжих бөгөөд тус бүс нутаг дахь хот суурин газруудад үрт хугацаанд тогтвортой ашиглагдах биет дэд бүтцийн болон нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмж сайжирна. Хэрэгжиж буй төслийн гол гол үр дүнд хотын шинэ замууд, цэвэр усны хангамжийн болон дулааны сүлжээд, ариутгах татуургууд, хатуу хог хаягдал цуглуулах, байршуулах шийдлүүд болон нийтийн аж ахуйн үйлчилгээг хүргүүлэх тогтолцооны шинэтгэл багтаж байна.

Хамгийн нэн түрүүнд гарах ёстой төслийн үр дагаврыг техник эдийн засгийн судалгааны (ТЭЗҮ) шатанд тодорхойлсон. Засгийн Газрын зүгээс Сайншанд, Даланзадгад хотуудад шинэ цэвэрлэх төв байгууламжуудыг улсын төсвөөс санхүүжүүлж барихаар төлөвлөсөн хэдий ч төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүдэн уг байгууламжууд баригдаагүй тул нэмэлт санхүүжилтийн хүрээнд барьж байгуулахаар багтаан оруулсан. Нэмэлт санхүүжилт хэрэгжсэнээр газар зүйн болон эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдал, бохир ус цэвэрлэх харьцангуй адил хэрэгцээ бүхий аймгуудад ашиг тустай жишиг бий болно хэмээн үзэж байна. Тиймээс нэмэлт санхүүжилтээр хэрэгжих төслийн хамрах хүрээнд Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хот болон Архангай аймгийн төв Цэцэрлэг хотуудыг Засгийн газрын санаачлагаар багтаасан болно.

Төслийн үр нөлөө Эдийн засгийн хөгжлийг дэмжих, аймгийн төвүүд (уул уурхайн суурьшлын төвүүд болон Өмнийн Говь д Өмнийн Говь дахь хил орчмын хот суурин газрууд)-ийн тав тухтай нөхцөл байдал сайжирна

Төслийн үр дагавар Засаглал бэхжин тус бүс нутаг дахь хот суурин газруудад урт хугацаанд тогтвортой ашиглагдах биет дэд бүтцийн болон нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмж дээшилнэ

Зорьсон үр дагаварт хүрч буй байдал

Хэрэгжилтийн явц

Төслийн үр дагавруудын талаарх тайлбар Инженерийн дэд бүтцийн үйлчилгээний шинэтгэл, үүн дотор нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт үр дүнд суурилсан гэрээний тогтолцоог нэвтрүүлэх ажил хэр эний тогтолцоог нэвтрүүлэх ажил хэрэгжинэ

Хот төлөвлөлт ба бодлого тодорхойлолт, үүн дотор төсөлд хамрагдсан хотуудын ерөнхий төлөвлөлт бэхжинэ

Хил дамнасан харилцаа хамтын ажиллагааг бий болгоно

Усны нөөц, дамжуулалт, хадагалалт, түгээлт цогцоор хэрэгжинэ
Бохир ус хүлээж авах ариутгах татуургуудыг байгуулж байнгын ашиглалтад оруулна

Дулааны шугам сүлжээдийг барьж байгуулан байнгын ашиглалтад оруулна

Хатуу хучилттай замууд баригдана

Хатуу хог хаягдал цуглуулах, бүлшлах шийдлүүд оновчлогдоно

Үер усны гадагшлуулах гайгууламжуудыг барьж байнгын ашиглалтад оруулна

Төслийн удирдлага,стратги төлөвлөлт, нягтлан бодох бүртгэл үйлдэх чадавхи бэхжинэ

Төслийн хэрэгжилтийн явц (үр дагавар, үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлууд)

Газар зүйн байршил

Хамгаалал хэрэгжих салбар асуудлууд:

Байгаль орчны асуудал	В
Албадан нүүлгэн шилжүүлэлт	С
Уугуул иргэд	С

Байгаль орчин нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчин	<p>Одоо хэрэгжиж буй болон нэмэлт санхүүжилтээр хэрэгжихтөслийн байгаль орчны нөлөөллийн ангилал “В” байгаа нь байгаль орчинд эргүүлж үл болох үлэмж нөлөөллийг үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой. Нэмэлт санхүүжилтээр хэрэгжих бүрэлдэхүүн хэсгүүдэд зориулж байгаль орчны анхдагч үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө зэргийг АХБ-наас 2009 онд гаргасан Хамгааллын бодлогын мэдэгдэлтэй нийцүүлэн боловсруулсан. Барьж байгуулах шатанд газар шорооны болон барилга угсралтынажлаас үүдэлтэй тоосжилт, дуу чимээ, хог хаягдал зэрэгбайгаль орчинд үзүүлэх богино хугацааны нөлөөлөл, мөн түүнчлэн нийгмийн болон мэргэжлийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл буй болно. Үндсэн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хэрэгжүүлэх сургалт, чадавхижуулах, мониторинг зэрэг нь үйл ажиллагаанаас буй болох нөлөөлөл, эрсдэлийг бууруулж байгаль орчны эерэг нөлөөлөл\үр ашгийг улам бүр нэмэгдүүлнэ. Байгаль цаг уурын эрсдэлийн хувьд төсөл доогуур ангилалд багтана.</p>
Албадан нүүлгэн шилжүүлэлт	<p>Одоо хэрэгжиж буй болон нэмэлт санхүүжилтээр хэрэгжих төслийн албадан нүүлгэн шилжүүлэлтийн ангилал “С” байгаа нь газар шилжүүлэн авалт, нүүлгэн шилжүүлэлтээс үлбаалах шүүд болон шүүд бус, түр хугацааны болон байнгын нөлөөлөл буй болохгүй. Цэвэрлэх байгууламжуудыг төрийн мэдлийн, ашиглагдаагүй газарт барьж байгуулна.</p>
Уугуул иргэд	<p>Уугуул иргэдийн асуудлаар “С” ангилалтай байгаа нь аль нэг тодорхой хүн ам, нийгмийн цөөнх аж төрдөг гэж үзэхгүй хот суурин газруудад төсөл хэрэгжих гэж байгаатай холбоотой. Бохир усны асуудал шийдэгдэж үйлчилгээ сайжирсны ашиг шимийг бүх оршин суугчид адил тэгш хүртэнэ. Уугуул иргэдтэй холбогдох АХБ-ны бодлогын шинжтэй нөхцөл шаардлага энэхүү төсөлд хамаарахгүй.</p>

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед Байгаль орчны анхдагч үнэлгээ, Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийх явцад оролцогч талуудтай хийсэн үүлзалтуудаас нэмэлт санхүүжилтээр хэрэгжих төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох орон нутагт ихээхэн дэмжиж байгаа нь харагдсан. АХБ-наас 2009 онд гаргасан Хамгааллын бодлогын мэдэгдэлтэй нийцүүлэн, төсөлтэй холбогдох байгаль орчны мэдээллийг нөлөөлөлд хамаарах талууда дараах байдлаар хүргүүлнэ: 1\ байгаль орчны анхдагч үнэлгээний тайланг 2016 оны 1-р сард нийтэд ил тод болгож АХБ-ны в вэб сайтад байршуулсан бөгөөд НААҮ-ний компаниудын болон төслийн удмрдлагын нэгжийн ажлын байранд хэлэлцэх боломжийг олгон байршуулсан, 2\ Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОНХАЖ-аас батлан нийтэд зориулан нийтэлнэ, 3\Байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг илтнэх жилийн тайлангууд болон төслийн эцсийн тайланг www.adb.org сайтад байршуулна.

Төслийн хэрэгжилтийн үед Төсөл хэрэгжих явцад нөлөөлөлд хамаарах иргэдийг НААҮБ-ын дэмжигч бүлэг, LIEC-ээс албан ёсны санал асуулга авах, биеэр очиж байдалтай танилцах, албан бусаар санал солилцох аргаар оролцуулж, мэдээллээр хангана. Байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх, иргэд олон нийтийн санал бодлыг сонсох, авч хэрэгжүүлэх арга хэмжээг харилцан тохиролцоо зорилгоор төслийн дунд хугаацааны үнэлгээг угтуулан нээлттэй хэлэлцүүлгүүдийг НААҮБ-ын дэмжигч бүлгийн зүгээс зохион байгуулна. Төслийн эцсийн тайлангийн айчлалыг угтуулан LIEC-ийн зүгээс төслийн хэрэгжилтийн талаарх орон нутаг иргэдийн сэтгэл ханамж, нэмэлт санхүүжилтийн бодит үр дагавар, Байгаль хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн байдал зэргийг үнэлэх судалгааны ажлыг зохион байгуулна. Судалгааны үр дүнг Төслийн эцсийн тайланд тусгана.

Бизнесийн боломжих,

Худалдан авалт АХБ-ны зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээний бүх худалдан авалтыг АХБ-ны худалдан авалтад мөрдөх журмын дагуу хэрэгжүүлнэ (2015 онд анх батлагдаж түүнээс хойш үе үе шинэгдэгдэн батлагддаг журам).

Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан Антонио Рессано Гарсиа

АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Хот, нийгмийн салбарын асуудал хариуцсан хэлтэс, Зүүн Азийн Газар
Хэрэгжүүлэгч байгууллага	Азийн Хөгжлийн Банк АХБ-ны өргөн чөлөө, Мандалуонг хот 1550, Филиппин Барилга, хот байгуулалтын яам Улаанбаатар 211238 Барилгачдын талбай 3, Монгол Улс

Цагалбар

Концепцийг батласан огноо

Баримтжуулах судалгаа хийгдсэн хугацаа 2015 оны 11-р сарын 30-аас 2015 оны 12-р сарын 4

Удирдлага хянан хэлэлцэх хурлын огноо

Төсөл батлагдсан огноо 2016 ны 4-р сарын 22

Сүүлд хийгдсэн хяналтын айлчлал -

ТМТ-д сүүлд өөрчлөлт хийгдсэн огноо 2016 оны 3-р сарын 31

MON 3388-MON 3ЭЭЛ

Гол огноонууд

Батлагдах өдөр	Гарын үсэг зурах өдөр	Хүчин төгөлдөр болох өдөр	Хаагдах өдөр		
			Гэрээгээр	Тодотгосон	Бодит
2016 оны 4-р сарын 22	-	-	2020 оны 6-р сарын 30	-	-

Санхүүжилтийн төлөвлөгөө

Зээлийн ашиглалт

	Нийт (ам.дол-аар илэрхийлсэн нийт дүн)	Огноо	ADB	Бусад	Цэвэр хувь
Төслийн өртөг	21.17	Гэрээлэлт хуримтлагдсан дүнгээр			
АХБ	19.43	2016 оны 4-р сарын 22	0.00	0.00	0%
ЗГ-ын хариуцах санхүүжилт	1.74	Зарцуулалт хуримтлагдсан дүнгээр			
Хамтран санхүүжүүлэлт	0.00	2016 оны 4-р сарын 22	0.00	0.00	0%

ТА 9100-MON

Гол огноонууд

Батлагдах өдөр	Гарын үсэг зурах өдөр	Хүчин төгөлдөр болох өдөр	Хаагдах өдөр
			Гэрээгээр
2016 оны 4-р сарын 22	-	-	2018 оны 10-р сарын 31

Санхүүжилтийн төлөвлөгөө/ТТ-ны ашиглалт

Зарцуулалт хуримтлагдсан дүнгээр

АХБ	Хамтран санхүүжүүлэлт	ЗГ-ын хариуцах санхүүжилт			Нийт	Огноо	Дүн	
		ЗГ	Төслийн үр шимийг хүртэгсэд	Төслийг дэмжигчид				Бусад
0.00	1,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	1,000,000.00	2016.04.22	0.00

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү баримт нь амьд баримт бичиг тул зарим нэг мэдээлэл тайлангийн анхны хувилбарт багтаагүй хэдий ч бэлэн болмогцоо дараачийн хувилбарт багтаж болно. Санал болгож буй төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээлэл болгон хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилууж байна. Тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэлийг хийгээгүй болно.